

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН 14-Р БАГИЙН 1А БАЙРНЫ АРЫН
ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨСӨЛ**

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан сумын 14-р багийн 1а байрны арын замын хажуу талын зүлэгжүүлэлтийн төсөл
2	Төслийн төрөл	Ногоон байгууламж, орчны тохижилт
3	Төслийн хэрэгжих байршил	1а байрны арын авто замын хажуу тал
4	Төслийн зорилго	Хотын авто замын өргөтгөлтэй холбоотойгоор устгагдсан ногоон байгууламжийг сэргээж, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх
5	Төслийн үндэслэл	Өмнө нь уг замын дагуу өндөр улиас моднууд байсан бөгөөд хотын өргөтгөлтэй холбоотойгоор устгагдаж, орчин ногоон байгууламжгүй болсон
6	Төслийн зорилт	<ul style="list-style-type: none"> - Зүлэгжүүлэлт хийх - Орчны тоосжилтыг бууруулах - Хотын гоо зүйг сайжруулах - Иргэдийн амьдрах орчны чанарыг дээшлүүлэх
7	Хэрэгцээ, шаардлага	Ногоон байгууламжгүй болсноор тоосжилт, халалт нэмэгдэж, орчны тав тух буурсан тул экологийн тэнцвэрийг сэргээх зайлшгүй шаардлагатай
8	Хэрэгжих хугацаа	2026 он (IV–VI сар)
11	Төслийн үйл ажиллагаа	Газрын тэгшилгээ, хөрс бэлтгэх, зүлэгний үр тарих, усалгааны систем
12	Нийт төсөв	12,190,000 төгрөг
13	Хүрэх үр дүн	<ul style="list-style-type: none"> - Тоосжилт буурна - Орчны гоо зүй сайжирна - Ногоон байгууламжийн хүртээмж нэмэгдэнэ
14	Тогтвортой байдал	Оршин суугчдын оролцоотой арчилгаа, хамгаалалт хийгдэж, урт хугацаанд ашиглагдана

1. Төслийн хэрэгцээ, шаардлага: Өмнө нь уг замын дагуу өндөр улиас моднууд ургаж, тухайн бүсийн бичил орчныг зохицуулах, тоосжилт бууруулах, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байсан. Гэвч хотын авто замын өргөтгөл, дэд бүтцийн ажлын хүрээнд эдгээр улиас моднуудыг устгаснаар тухайн хэсэг ногоон байгууламжгүй болж, дараах сөрөг нөлөөллүүд үүсээд байна. Үүнд:

- Тоосжилт, шороон шуурга нэмэгдэх
- Зуны улиралд халалт ихсэх

- Орчны гоо зүй алдагдах
- Оршин суугчдын тав тух буурах

Иймд ногоон байгууламжгүй болсон энэхүү газрын экологийн тэнцвэрийг сэргээх, орчны тав тухыг сайжруулах зорилгоор зүлэгжүүлэлтийн ажлыг зайлшгүй хийх шаардлага үүссэн.

2. Төслийн үндэслэл

- Монгол Улсын “Ногоон хөгжлийн бодлого”
- Хот, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төрийн бодлого
- Дархан-Уул аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө
- Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах шаардлага
- Хотын авто замын өргөтгөлөөс үүдэлтэй экологийн сөрөг нөлөөллийг бууруулах зайлшгүй нөхцөл

3. **Төслийн зорилго:** Дархан-Уул аймгийн Дархан сумын 14-р багийн 1а байрны арын замын дагуу хотын авто замын өргөтгөлтэй холбоотойгоор устгагдсан ногоон байгууламжийн орчныг сэргээж, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, бичил экологийн тэнцвэрийг сайжруулахад оршино.

4. **Төслийн зорилт** Төслийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Устгагдсан ногоон байгууламжийн оронд зүлэгжүүлэлт хийж, орчны тохижилтыг сайжруулах
- Тоосжилт, дуу чимээ, халалтыг бууруулах ногоон зурвас бий болгох
- Оршин суугчдын амрах, алхах орчныг илүү таатай болгох
- Хотын ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Орчны гоо зүй, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх

5. **Төслийн хүрэх үр дүн.** Төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүнгүүд бий болно. Үүнд:

- Зүлэгжүүлэлт хийснээр тухайн бүсийн тоосжилт 20–30 хувиар буурна
- Орчны гоо зүй, ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэнэ
- Оршин суугчдын эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах орчин бүрдэнэ
- Хотын бичил уур амьсгал сайжирна
- Иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ

6. Төслийн үйл ажиллагаа

- Газрын тэгшилгээ, хөрс бэлтгэх
- Үржил шимт хар шороо асгах
- Зүлэгний үр тарих
- Усалгааны анхан шатны шийдэл хийх
- Арчилгаа, хамгаалалтын ажил

7. Санхүүгийн тооцоо (нийт: 12,190,000 төгрөг)

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт	Техникийн үзүүлэлт / норм
1	Талбай цэвэрлэгээ, хог хаягдал түүх, чулуу ялгах, улиас модны үндэс цэвэрлэх	м ²	700	3,000	2,100,000	Гадаргуу цэвэрлэгээ
2	Тэгшилгээ, налуу үүсгэх, нягтруулалт (суурь)	м ²	700	600	420,000	1–2% налуу, шавхалт сайжруулах
3	Үржил шимт хөрс тээвэрлэн асгах, тараах	м ³	70	20,000	1,400,000	10 см үе = 70 м ³
4	Компост/органик хөрс сайжруулагч	м ³	7	80,000	560,000	10% = 7 м ³
5	Эрдэс бордоо (NPK)	кг	70	6,000	420,000	100 г/м ² = 70 кг
6	Зүлэгний үр (хольц)	кг	42	35,000	1,470,000	60 г/м ² = 42 кг
7	Хучлага (хүлэр/мульч), үр булалт	м ³	7	90,000	630,000	0.01 м = 7 м ³
8	Багаж, жижиг материал (утас, шон, шүүр, тармуур, хамгаалалтын хэрэгсэл гэх мэт)	багц	1	520,000	520,000	Багц
9	Ажиллах хүч-зүлэгжүүлэлтийн бригад	хүн-өдөр	20	80,000	1,600,000	2 хүн × 10 өдөр (жишиг)
10	Усалгааны шланк	м	150	3,000	450,000	2 эгнээ усалгааны систем
11	Усалгаан цацруулагч хошуу	ш	20	44,000	880,000	35 м ² талбай*20
12	Тээвэр, бусад тусгай зориулалтын техникийн зардал	багц	1	1,740,000	1,740,000	Улиас модны үндэс цэвэрлэх техник, хөрс сийрүүлэх, шигших, бусад техник
Нийт					12,190,000	